

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны ... сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын
шуурхай албаны ажиллах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны журам” –ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчид болон Албан журмын даатгагчдын холбоо дагаж мөрдсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ШУУРХАЙ АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар даатгагч, даатгуулагч, хохирогч, холбогдогчоос даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “даатгал” гэх/-ын шуурхай алба /цаашид “шуурхай алба” гэх/-ны бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шуурхай алба нь даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг тодорхойлох, баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай олгох боломжийг бүрдүүлэх, холбогдох мэдээллийг мэдээллийн санд бүрэн нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

ХОЁР. Шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, тавигдах шаардлага

2.1. Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь шуурхай албаны үйл ажиллагаандаа энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2.2. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагчийн шуурхай алба нь улсын хэмжээнд үйлчлэх нэгдсэн удирдлага, зохион байгуулалт бүхий дуудлага хүлээн авах нэгдсэн төвтэй байна.

2.3. Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч, түүний аймаг, нийслэл дэх салбар нь тухайн орон нутгийн шуурхай албаны үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан жолоочийн дуудлагыг хамтран ажиллах гэрээгээр эрх бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

2.4. Даатгагчийн шуурхай алба нь даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авах оператор, дуудлагын ажилтан, ахлах ажилтан/дарга/ гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Орон нутагт эрх бүхий даатгагчын салбарын ажилтан нь шуурхай албаны үйл ажиллагааг хариуцан ажиллана.

2.5. Шуурхай алба болон түүний ажилтнууд дараах шаардлага, шалгуурыг хангасан байна.

Үүнд:

- 2.5.1. Шуурхай алба нь ажлын байртай, даатгалын тохиолдлын дуудлагыг хуанлийн бүх хоногт 24 цагийн турш хүлээн авах, даатгалын тохиолдлыг тодорхойлж, баримтжуулахад шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжтэй, дуудлагад хүрч ажиллах тээврийн хэрэгсэлтэй, мэдээллийн сангийн МИИС системд мэдээлэл нийлүүлэх нөхцлийг хангасан байна.
 - 2.5.2. Шуурхай албаны ажилтан нь нэр, хувийн дугаар, таних тэмдэг бүхий дүрэмт хувцас, энгэрийн зүүлт, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг, шалгалтын тэмдэглэлийг баталгаажуулах дардастай байна;
 - 2.5.3. Шуурхай албаны дуудлагын ажилтан нь автомеханикч, инженер эсхүл эрх зүйч мэргэжилтэй, мэргэшсэн жолооч байна;
 - 2.5.4. Шуурхай албаны нийт ажилтнууд Албан журмын даатгагчдын холбооноос баталсан хөтөлбөрийн дагуу анхан шатны болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, даатгалын хохирол үнэлэх эрхтэй байвал давуу талб болно.
- 2.6. Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь жолоочийн хариуцлагын даатгалын шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

ГУРАВ. Шуурхай албаны автомашин, дуудлагын ажилтны танигдах тэмдэг, бичиглэл

3.1. Шуурхай албаны тээврийн хэрэгсэл нь байгууллагын лого/эмблем/-той, “ШУУРХАЙ АЛБА”, “ДААТГАЛ” гэсэн бичиглэл, дуудлагын утасны дугаар, шар өнгийн туузан хэлбэртэй анивчдаг гэрэл, ослын газрыг тусгаарлах хэрэгсэл/тумб/-тэй, дуудлагын ажилтан нь энгэртээ нэр, ар талдаа “ШУУРХАЙ АЛБА” гэсэн бичиглэл бүхий өмсгөл /хантааз/-тэй байна.

3.2. 350 мм-ийн урт, өргөний хэмжээтэй байгууллагын лого/эмблем/-г шуурхай албаны автомашины урд талын хоёр хаалганд, бусад тээврийн хэрэгслийн ил харагдах хэсэгт тус тус байрлуулна.

3.3. MNS 4333:96 стандартын дагуу 100x60 мм хэмжээст үсэг бүхий “ДААТГАЛ” бичиглэлийг шуурхай албаны автомашины хамар (капот) дээр, “ШУУРХАЙ АЛБА” бичиглэлийг хоёр хажууд /3 дугаар хавсралтын дагуу/ тус тус голлуулан, 90x55 мм хэмжээст тоо бүхий дуудлагын утасны дугаарыг хойд талын хоёр хаалганы урд ирмэгээс 50 мм, доод ирмэгээс 200 мм зайд тус тус бичнэ.

3.4. Дуудлагын ажилтны хантаазны ар талд “ШУУРХАЙ АЛБА” гэсэн 50x30 мм хэмжээст үсэг бүхий бичиглэлийг захнаас доош 100 мм зайд голлуулж, 12x10 мм хэмжээст үсэг бүхий овгийн эхний үсэг, нэрийг энгэр хэсэгт тод харагдахаар /журмын 3 дугаар хавсралтын дагуу/ бичнэ.

ДӨРӨВ. Даатгалын тохиолдлын тухай мэдээлэл хүлээн авах, бүртгэх

4.1. Нэгдсэн дуудлага хүлээн авах төвийн оператор нь дараах ажил үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

4.1.1 Зам тээврийн ослын мэдээлэл, дуудлагыг энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтаар хүлээн авч Холбооны мэдээллийн нэгдсэн санд илгээж дугаар авна. Дугаар нь 9 оронтой тоо байх бөгөөд тухайн оны сүүлийн 2 орон, даатгалын компаний код, дэс дугаар гэсэн бүтэцтэй байна.

4.1.2. Тухайн зам тээврийн осолд буруутай этгээд нь тодорхойгүй, холбогдогчийн гэм буруутай нь тогтоогдоогүй, маргаантай, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан, бусад хууль, дүрэм, журамтай харшилж байвал замын цагдаагийн байгууллагад мэдэгдэхийг зөвлөх;

4.1.3. Замын хөдөлгөөний дүрмийн 3.6-д заасан нөхцөл үүссэн үед шуурхай алба зам тээврийн ослын газар дээр очиж даатгалын тохиолдлыг тодорхойлох хүртэл тээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх, ослын газрыг орхиж явахгүй байхыг анхааруулах;

4.1.4. Зам тээврийн ослын газарт шуурхай алба очих боломжгүй, бусдын амь нас, эрүүл мэнд хохироогүй, ослоос үүдсэн эд хөрөнгийн хохирлыг жолооч, холбогдогчид өөр хоорондоо харилцан маргаангүй шийдвэрлэхээр тохиролцсон, зам тээврийн ослыг баримтжуулсан /гэрэл зураг, бичлэг, гэрчтэй бол түүнээс тодорхойлолт болон хаяг, утсыг нь авах гэх мэт/ бол, нөхөн төлбөр авахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар баталсан маягтыг бөглөх талаар зөвлөгөө өгөх

4.2. Оператор нь зам тээврийн ослын талаарх мэдээлэл хүлээн авсан даруйд дуудлагын ажилтанг нэн даруй хуваарилах үүрэг хүлээнэ.

ТАВ. Даатгалын тохиолдлын газар дээрх ажиллагаа

5.1. Зам тээврийн ослын газар дээр очсон дуудлагын ажилтан зам тээврийн осол болсон газрын нэр, зам орчны байдал, цаг хугацаа, буруутай этгээд, хохирогч болон бусад холбогдогч нарыг бүртгэх даатгалын тохиолдолд холбогдох бусад баримтуудыг баталгаажуулж авах зорилгоор дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

5.1.1. Зам тээврийн ослын газарт ирмэгц замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн хэсэг газрыг тойруулан хаалт /тумб/ тавих;

5.1.2. Зам тээврийн ослын улмаас хүний биед гэмтэл учирсан бол эмнэлгийн тусламж яаралтай дуудах, шаардлагатай бол эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

5.1.3. Зам тээврийн осол гаргасан этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мансуурсан, бичиг баримтгүй, насанд хүрээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн бол түүнийг замын цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.1.4. Зам тээврийн ослын үед хэн нэгний буруу, зөвийг тодорхойлоход нөхцөл байдал хүндрэлтэй, эргэлзээтэй, маргаантай байх үед ямар нэг дүгнэлт урьдчилж гаргахгүй байх, тэнд байгаа хүмүүстэй эелдэг харилцах, шаардлагатай тохиолдолд замын цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

5.1.5. Зам тээврийн осол холбогдсон жолооч нараас нэмэлтээр тайлбар бичүүлж авч болно.

5.1.6. Дуудлагын ажилтан нь даатгалын гэрээ, холбогдох бичиг баримтыг шалгаж ослын газар дээр тэмдэглэл үйлдэж, онцгой шинж тэмдгүүд, нөхцөл байдлыг оролцуулан видео эсхүл фото зургаар тээврийн хэрэгслийн эвдрэлийн зургийг ерөнхий болон хэсэгчлэн, бодитоор харагдахуйц байдлаар, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг оруулан баримтжуулах;

5.1.7. Даатгалын тохиолдол мөн эсэхийг тодорхойлох;

5.2. Даатгалын тохиолдлын газарт дуудлагаар очиход уг тохиолдолд буруутай жолооч тухайн шуурхай албаны харьяаллын бус байвал холбогдох даатгагч, жолоочийн даатгалын санд мэдэгдэж, ослын газрын тэмдэглэл, баримтыг даатгагч, жолоочийн даатгалын санд шилжүүлнэ. Даатгагч, Жолоочийн даатгалын сангийн дуудлагын ажилтан энэ тохиолдолд болон 4.1.4 дэх хэсэгт заасан нөхцөл, байдлын дараа шаардлагатай гэж үзвэл нөхөн үзлэг хийх, баримтжуулах ажиллагааг хийж болно.

5.3. Дуудлагын ажилтан нь даатгалын тохиолдлын газар дээр үйлдсэн тэмдэглэлийг энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу бүртгэж Холбооны мэдээллийн нэгдсэн санд илгээж дугаар авна. Дугаар нь 11 оронтой тоо байх бөгөөд тухайн оны сүүлийн 2 орон, МИИС-т нэвтрэх хэрэглэгчийн дугаар, дэс дугаар гэсэн бүтэцтэй байна. Даатгалын тохиолдлын газар дээр үйлдсэн тэмдэглэл, холбогдох зураг, видео бичлэг, баримт материалыг энэ журмын 1, 2 дугаар хавсралтын хамт холбогдох даатгагч, жолоочийн даатгалын сангийн нөхөн төлбөр хариуцсан ажилтанд илгээнэ.

5.4. Даатгалын тохиолдлын хохирогчийн хүсэлтээр тээврийн хэрэгслийн хохирлын хэмжээг тогтоовол хохирлын тухай мэдээллийг Холбооны мэдээллийн нэгдсэн санд илгээж дугаар авна. Дугаар нь тохиолдлын болон үнэлгээний дугаар, сериалын 2 үсгээс бүрдэнэ. Хэрэв хохирогчийн тээврийн хэрэгсэлд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах эрхтэй.

ЗУРГАА. Хэрэгжилт, хяналт, хариуцлага

6.1. Даатгагч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албаны үйл ажиллагааны жилийн тайлангаа дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор багтаан Холбоонд ирүүлэх бөгөөд Холбоо нэгтгэн дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд хүргүүлнэ.

6.2. Холбоо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох баримтын хамт Хороонд хүргүүлнэ. Хорооны улсын байцаагч хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Дугаар:
(МС-аас олгоно)

.....
(аймаг, хот, дүүрэг)

1	Даатгалын тохиолдол болсон	огноо	
		цаг, минут	
2	Дуудлага хүлээн авсан	огноо	
		цаг, минут	
3	Дуудлага өгсөн хүний	овог, нэр	
		холбоо барих утас	
4	Даатгалын тохиолдол болсон газрын байршил		
5	Даатгалын тохиолдол болсон үеийн анхны аман мэдүүлэг		
6	Даатгалын тохиолдол гаргасан автотээврийн хэрэгслийн	марк, загвар	
		улсын дугаар	
7	Даатгалтай эсэх /Даатгагчийн нэр/		
8	Даатгалын гэрээний дугаар		
9	Даатгалын гэрээ байгуулсан хугацаа		
10	Даатгалын тохиолдол болсон газраас хөдөлсөн эсэх	үгүй <input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/> тийм	
11	Даатгалын тохиолдол болсон газарт очихоор томилогдсон дуудлагын ажилтны нэр		

Тусгай тэмдэглэл:
.....
.....(замын цагдаагийн байгууллагад мэдэгдэх эсэх талаар дэлгэрэнгүй бичих)

Дуудлага хүлээн авсан:

Шуурхай албаны оператор: /...../
(Гарын үсэг)(Гарын үсгийн тайлал)

Дуудлагад явахаар томилогдсон:

Дуудлагын ажилтан..... /...../
(Гарын үсэг)(Гарын үсгийн тайлал)

.....онсар.....өдөр.....цаг.....минут

ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ГАЗАР ДЭЭРХ ТЭМДЭГЛЭЛ

Дугаар:
(МС-аас олгоно)

20... оны ...-р сарын ...-ны өдөр

.....

(аймаг, хот, дүүрэг)

Шуурхай албаны дуудлагын ажилтан би
..... нарыг байлцуулж аймаг, хотын
..... сум, баг, дүүрэг, хорооны нутаг дэвсгэр
.....
.....гудамж, замд гарсан даатгалын тохиолдлын дуудлагыг оны
-р сарын -ны өдрийн цаг минутанд хүлээн авч, газар дээрх тэмдэглэлийг 20.... оны-р сарын
... -ны өдрийн цаг минутанд хийв.

Даатгалын тохиолдолд оролцсон автотээврийн хэрэгслийн тоо:

Даатгалын тохиолдлын улмаас гэмтсэн хүний тоо:

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ



		А тал/холбогдогч/	Б тал/хоширогч/
Тээврийн хэрэгслийн	марк		
	улсын дугаар		
	өмчлөгч		
	зорчигчийн тоо		
Жолоочийн	овог, нэр		
	регистрийн дугаар		
	үнэмлэхийн дугаар		
	хаяг		
	утасны дугаар		
Техникийн байдал			
Даатгагч			
Даатгалын гэрээний дугаар			

Даатгалын тохиолдлын шалтгаан, хэлбэр:

(тохирохыг зөвлөнө үү (✓))

Даатгалын тохиолдол болсон шалтгаан	Даатгалын тохиолдол гарсан хэлбэр
<input type="checkbox"/> Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	<input type="checkbox"/> ТХ ТХ-тэй урд талаараа мөргөлдсөн
<input type="checkbox"/> Уулзвар гарц нэвтрэх журам	<input type="checkbox"/> ТХ ТХ-тэй ард талаараа мөргөлдсөн
<input type="checkbox"/> Эсрэг урсгалд орсон	<input type="checkbox"/> ТХ ТХ-тэй хажуу талаараа мөргөлдсөн
<input type="checkbox"/> Ухрах үйлдэл буруу хийсэн	<input type="checkbox"/> ТХ-ээр барилга байгууламж, эд зүйл мөргөсөн
<input type="checkbox"/> Хурд хэтрүүлсэн	<input type="checkbox"/> Онхолдсон
<input type="checkbox"/> Гэрэл дохио зөрчсөн	<input type="checkbox"/> Явган зорчигч ТХ-ийн урдуур явж байхад мөргөсөн
<input type="checkbox"/> Эгнээ байр буруу эзэлсэн	<input type="checkbox"/> Явган зорчигч ТХ-ийн зэрэгцээ явж байхад мөргөсөн
<input type="checkbox"/> Эргэх үйлдэл буруу хийсэн	<input type="checkbox"/> Явган зорчигч зам дээр зогсож, ажиллаж байхад мөргөсөн
<input type="checkbox"/> Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	<input type="checkbox"/> Бусад
<input type="checkbox"/> Зогсоох арга хэмжээ аваагүй буюу буруу авсан	
<input type="checkbox"/> Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн	
<input type="checkbox"/> Бусад	

Тээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийг бүдүүвч дээр тодорхой тэмдэглэх



.....

Жолооч нарын бичгээр өгсөн тайлбар		
Даатгуулагч		Гарын үсэг
		огноо.....
Холбогдогч		Гарын үсэг
		огноо.....

Тусгай тэмдэглэл

.....

Газар дээрх тэмдэглэлийг хийж дууссан: цаг.....минут

Тэмдэглэл үйлдсэн:

Шуурхай албаны ажилтан: (.....)
 (дардас) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ШУУРХАЙ АЛБАНЫ АВТОМАШИН, ДУУДЛАГЫН АЖИЛТНЫ ӨМСГӨЛИЙН ЗАГВАР

- Шуурхай албаны автомашины өнгө, таних тэмдэг, дуудлагын ажилтны өмсгөл/хантааз/-ийн загвар.



50x30мм хэмжээс бүхий ШУУРХАЙ АЛБА хантаасны ард талд захнаас доош 100мм зайд голлуулна

12 x 10 мм хэмжээст үсэг бүхий овгийн эхний үсэг, нэрийг зүүн энгэрт тод харагдахуйцаар бичнэ

 -#FFFF00

100 мм x 60 мм хэмжээст үсэг бүхий ШУУРХАЙ АЛБА бичиглэлийг хоёр хажууд голлуулж байрлуулна.

100 мм x 60 мм хэмжээст үсэг бүхий ДААТГАЛ бичиглэлийг капот дээр голлуулж байрлуулна.



Урт өргөнөөрөө 350 мм бүхий хэмжээстэй байгууллагын лого/эмблем/-г урд талын хоёр хаалганд голлуулна

90 мм x 50 мм хэмжээст тоо бүхий дуудлагын утасны дугаарыг хойд талын хоёр хаалганы урд ирмэгээс 50 мм, доод ирмэгээс 200 мм зайд хөх өнгөөр бичнэ

12. Зам тээврийн осол гарсан замын нөхцөл байдал

“А”		“В”
Замын хучилт:		
<input type="checkbox"/> 1	Асф-бет	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Цем-бет	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	сайжруулсан	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	хөрсөн	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	хайрган	5 <input type="checkbox"/>
Замын гадаргуугийн байдал:		
<input type="checkbox"/> 1	хуурай	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	нойтон	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	цастай	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	мөстэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	эвдрэлтэй	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	бохирдсон	6 <input type="checkbox"/>
Замын хэсэг:		
<input type="checkbox"/> 1	уулзвар	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	гарц	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Явган хүний гарц	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Автобусны буудал	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Төмөр замын гарам	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	гүүр	6 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 7	хонгил	7 <input type="checkbox"/>

“А”		“В”
Үзэгдэх орчин:		
<input type="checkbox"/> 1	чөлөөтэй	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	хязгаарлагдмал	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	хангалтгүй	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Зорчих хэсэг гэрэлтүүлэгтэй	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Зорчих хэсэг гэрэлтүүлэггүй	5 <input type="checkbox"/>
Замын онцлог:		
<input type="checkbox"/> 1	тэгш	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	хазгай	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	шулуун	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	өгсүүр	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	уруу	5 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 6	Огцом эргэлт	6 <input type="checkbox"/>

“А”		“В”
Замын ангилал:		
<input type="checkbox"/> 1	Ердийн зам	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Хорооллын зам	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	Тууш зам	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	Хорооллын зам	4 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 5	Аж ахуйн нэгж байгууллагын доторхи зам	5 <input type="checkbox"/>
Бусад:		
<input type="checkbox"/> 1	Суурингийн замд	1 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 2	Суурингийн гаднах замд	2 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 3	өдөр	3 <input type="checkbox"/>
<input type="checkbox"/> 4	шөнө	4 <input type="checkbox"/>

13. Учирсан хохирол

“А” жолоочид
Учирсан эд материалын мөнгөн дүн:

Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:

“В” жолоочид


Учирсан эд материалын мөнгөн дүн:

Нөхөн төлүүлсэн мөнгөн дүн:

1. Замын дүрслэл – гудамжны нэрийг оруулна.
2. “А” ба “В” ТХ-ийн хөдөлгөөний чиглэл.
3. “А” ба “В” ТХ-ийн мөргөлдөх үеийн байрлал.
4. “А” ба “В” ТХ-ийн эцсийн байдал.
5. Замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохио.

14. Анхны цохилт өгсөн газар

Сумаар заах (→)



Гэмтлийн нүдээр харагдах байдал

“А”* ТХ-ийн жолоочийн гарын үсэг

.....

13.Зам тээврийн ослын товч утга:

15.Зам тээврийн ослын товч утга:

.....

.....


.....

.....

Хоёр жолооч бүртгэл бөглөснөөс хойш аливаа өөрчлөлт хийхийг хориглоно.

14. Анхны цохилт өгсөн газар

Сумаар заах (→)



Гэмтлийн нүдээр харагдах байдал

“В”* ТХ-ийн жолоочийн гарын үсэг

.....

16. Зам тээврийн осолд 2-оос дээш тооны ТХ оролцсон бол тэдгээр ТХ-ийн талаарх мэдээлэл

(ТХ-ийн марк, загвар, улсын дугаар;

даатгагч, даатгалын баталгааны сери, дугаар)

17. ТХ-д учирснаас бусад хөрөнгөд учирсан хохирол

Нэр төрөл _____ (гэмтсэн зүйлийн нэр төрөл)

Хэний хөрөнгө болох _____ (баримтаар нотлогдвол бөглөнө)

18. ТХ-ийг хөдөлгөж явуулах боломжтой эсэх? Тийм Үгүй

"Үгүй" бол ТХ хаана байгаа талаарх _____

19. Тэмдэглэл:

“ _____ ” 20 . _____)
(бөглөсөн огноо) (гарын үсэг) (Овог, нэр (гарын үсгийн тайлал))

Зам тээврийн осолд холбогдсон талууд маргаантай тохиолдолд цагдаагийн байгууллагад хандаж асуудлаа шийдвэрлүүлнэ.